



**ХЭВЛЭЛ
МЭДЭЭЛЛИЙН
ЗӨВЛӨЛ**



ЦАХИМ ОРЧИНД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН РЕДАКЦЫН БАРИМТЛАХ БОДЛОГО

(Редактор, сурвалжлагчдад зориулсан зөвлөмж)

2020 он



Уг зөвлөмжийг Фридрих-Эбертийн сангийн дэмжлэгтэйгээр хэвлэв. Агуулгыг Хэвлэл мэдээллийн зөвлөл хариуцах бөгөөд Фридрих-Эбертийн сангийн байр суурьд нийцэж байх албагүй болно.

АГУУЛГА

1. Өмнөтгөл

2. Цахим орчинд редакцын баримтлах бодлогын зөвлөмжүүд:

- Сэтгүүлч, сурвалжлагч үзэн ядалт, гутаан доромжлолд өртсөн тохиолдолд яах вэ?
- Сэтгүүлч, сурвалжлагч сошиал медиа орчинд биеэ хэрхэн зөв авч явах вэ?
- Сэтгүүлч сошиал медиад мэдээлэл түгээхдээ хувийн болон редакцын байр суурийг ялгах, “хоёр нүүр” гаргахгүй байх тухай
- Сэтгүүлч хуурамч мэдээллийг ялгаж таних чадвартай байж, хуурамч мэдээллийг түгээхгүй байх
- Сэтгүүлч сошиал медиад мэдээлэл түгээхдээ үзэн ядалтын үг хэллэгийг ашиглахгүй байх
- Хэвлэл мэдээллийн зөвлөлийн уриалга 2017-2020 онд
- Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим



Чингисийн өргөн чөлөө, СБД



976- 70000610



www.mediacouncil.mn



Хэвлэл мэдээллийн зөвлөл

ӨМНӨТГӨЛ

Дижитал хувьсал, алгоритм, технологийн үеийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хамгийн том сорилт бол нийгмийн хэвлэл мэдээлэл (Сошиал медиа) болж байна. Уламжлалт сэтгүүл зүйн ноёрхлын үед зөвхөн сэтгүүлчид мэдээлэлд хүрч, түүнийг боловсруулж олон нийтэд хүргэдэг байсан бол өнөөдөр байдал эрс өөрчлөгджээ. Хэрэглэгчид мэдээллийн эх сурвалж болохоос гадна мэдээллийг түгээгч, дамжуулагч, идэвхтэй хуваалцагч болж байна.

Мэдээллийг түргэн шуурхай түгээхээс илүү нягталсан баталгаатай мэдээллийг түгээх нь сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн (Journalism Media) нэн тэргүүний зорилт юм. Сэтгүүл зүйн хэвлэл мэдээлэл нь дагаж мөрдөх ёс зүйн дүрэм, хариуцлага хүлээх чадвараараа нийгмийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд (Social Media) байгаа иргэдээс эрс ялгаатай. Өөрөөр хэлбэл, жирийн иргэн нийгмийн сүлжээнд юу хэлэх, хэрхэн илэрхийлэх нь тухайн хүний сонголтоос шалтгаалдаг. Харин сэтгүүлч редакцын үйл ажиллагаандаа төдийгүй нийгмийн сүлжээнд ч ёс зүйн хэм хэмжээнээсээ халихгүй байх (мэдээллийг нягтлан шалгах, эх сурвалжуудаар баталгаажуулах, баталгаагүй таамаг төдий мэдээллийг нийтэд түгээхээс түтгэлзэх, хохирогчийг хамгаалах, хувь хүний нэр төр, хувийн нууцад хүндэтгэлтэй хандах гм) мэргэжлийн үүрэг, хариуцлагыг хүлээдэг. Сэтгүүл зүйн өдөр тутмын үйл ажиллагаанаас урган гарсан 10 бүлэг 24 заалттай “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ыг сэтгүүлчид мөрдлөг болгодог.

Олон нийт нийгмийн мэдээллийн хэрэгслээс илүүтэй сэтгүүл зүйн хэвлэл мэдээлэлд итгэл үзүүлдэг. Сэтгүүл зүй бол олон нийтийн итгэл үнэмшлийг тээж явдаг мэргэжил. Иймээс хэвлэл мэдээллийн гол зорилго нь олон нийтийн энэхүү итгэлийг алдахгүй байх явдал юм. Хуурамч мэдээлэл, суртал ухуулга, үзэн ядсан үг хэллэг эрчимтэй тархаж, үнэн ба худал хоёрыг ялгахад бэрх болсон өнөө цагт ёс зүйтэй, хариуцлагатай сэтгүүл зүйн үүрэг, роль улам бүр тодорч байна. Түүнчлэн редакцын дотоод дүрэм журам, ёс зүйн зарчим, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын ач холбогдол, гүйцэтгэх үүрэг ч үүнийг даган өсөн нэмэгдсээр байна.

Иймд ХМЗ-өөс редактор, сурвалжлагч нарт зориулсан “Цахим орчинд хэвлэл мэдээллийн баримтлах бодлого” гарын авлагыг бэлтгэлээ. Энэхүү баримт бичиг нь та бүхний өдөр тутмын үйл ажиллагаанд чиг шугам болж, мэргэжлийн ёс зүйгээ нийгмийн мэдээллийн хэрэгсэлд чанд мөрдөн бусдыг манлайлах, улмаар цахим орчин дахь ёс бус халдлагаас өөрсдийгөө хамгаалахад ч тус дэм болно хэмээн итгэж байна.

Хэвлэл мэдээллийн зөвлөл нь ардчилсан улс орнуудын нийтлэг жишгийн дагуу хэвлэл мэдээллийн эрх чөлөөг дэмжих, хэвлэл мэдээлэл хэрэглэгчдийн үнэн бодит мэдээлэл авах эрхийг хамгаалах, сэтгүүл зүйн мэргэжлийн ёс зүйг сахиулах зорилготой хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага юм.

Энэхүү гарын авлагыг бэлтгэхэд гүн туслалцаа үзүүлж, мэргэжлийн хувь нэмэр оруулсан ХМЗ-ийн РТВ-ийн ёс зүйн хорооны гишүүн Ж.Хулан, ССС-ын ёс зүйн хорооны гишүүн О.Ариунбилэг нарт, түүнчлэн хэвлэмэл хувилбарыг бэлтгэн гаргахад дэмжлэг үзүүлсэн Фридрих-Эбертийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт талархал илэрхийлье.

Г.Гүнжидмаа, ХМЗ-ийн Гүйцэтгэх захирал



Нэг. СЭТГҮҮЛЧ, СУРВАЛЖЛАГЧ ҮЗЭН ЯДАЛТ, ГУТААН ДОРМЖЛОЛД ӨРТСӨН ТОХИОЛДОЛД ЯАХ ВЭ?

Олон нийтийн эрх ашгийн өмнөөс бэлтгэсэн нийтлэл, нэвтрүүлэгтэй нь холбоотойгоор цахим орчинд сэтгүүлч рүү хомроглон дайрах, элдвээр доромжлох, заналхийлэх зэрэг тохиолдол цөөнгүй гарах болжээ. Энэ нь сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад болж, хувь хүний сэтгэл зүйд сөргөөр нөлөөлдөг тул сэтгүүлч өөрөө төдийгүй түүний хамт олон, удирдлага үүнийг хэрхэн даван туулах тухай мэдлэгтэй байх нь чухал юм.



Сэтгүүлчдэд өгөх зөвлөмж:

- Танд хандсан үзэн ядаж, гутаан доромжилсон, заналхийлсэн материалуудыг хадгал.
- Үзэн ядсан агуулгатай зурвас илгээж буй хүмүүсийг найзаасаа хасах, блоклох зэрэг арга хэмжээ ав (Facebook, Instagram...). Фэйсбүүкт найзаасаа хасах нь эргээд өөр замаар доромжлол хүлээхэд хүргэхээр бол найзаасаа хасахгүйгээр unfollow хийх. Ингэснээр найз хэвээр байх боловч тухайн хүний постууд өөрт чинь харагдахгүй болно.
- Урам хугалсан олон тооны зурвас, сэтгэгдлийг уншиж ангилан, ялгах нь таны сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөхөөр бол үүнийг өөр хүнээр хийлгэ. Ажлын найзаараа сошиал хуудас болон и-мейлээ “цэвэрлэж”, цэгцлүүлж болно.
- Дарга, удирдлагадаа шүүмж, доромжлолын бай болж буйгаа мэдэгд. Ажил олгогч чинь энэ талаар мэдэж, шаардлагатай арга хэмжээг авч, туслах ёстой.
- Дата болон онлайн аюулгүй байдлаа эргэж хар. Таньж, мэдэхгүй хүмүүс сошиал хуудсаас чинь мэдээлэл харах боломжтой юу, нууц үг чинь хангалттай хүчтэй юу, хоёр шатлалт хамгаалалт авсан уу зэргээ шалгаарай.
- Утасны дугаар, гэрийн хаяг зэрэг мэдээлэл чинь нууц байж, зөвхөн

редакцын утсаар хүмүүстэй холбогдоно гэдгээ хамт олондоо хэлж, эдгээр мэдээллийг хамгаалахыг хүсээрэй.

- Утсаар залгаж үзэн ядсан яриа, хараал, заналхийлэл хэлсэн бол болгоомжтой байх хэрэгтэй. Утасны яриаг чинь бичиж, мөн цаашлаад эвлүүлэг хийх магадлалтай.
- Ийм үед сэтгэл зүйгээ тайван байлгаж, сэтгэцийн эрүүл мэндээ анхаарах нь чухал. Тиймээс шаардлагатай бол нөхцөл байдал намжтал түр зуур ажлаасаа завсарлаж болно.
- Хэн ч үзэн ядалтын бай болох магадлалтай. Тиймээс хэтэрхий хүндээр тусгаж авах хэрэггүй.



Редакцын удирдлагуудад зөвлөх нь:

- Сэтгүүлч, сурвалжлагч нар өөрийг нь үзэн ядаж, гутаан доромжилсон аливаа дуудлага, текст, и-мейлээ танд үзүүлэхийг хүсэхгүй эсвэл хэрхэн тусгаж авч буйгаа шуудхан хэлэхгүй байж мэднэ. Гэсэн хэдий ч нөхцөл байдлыг ойлгож, зөвөөр үнэлж дүгнэх хэрэгтэй.
- Ажил олгогчийн зүгээс ямар тусламж шаардлагатай байгааг асуугаарай. Түүнчлэн онлайн хэвлэл болон сошиал медиа хуудсуудад сэтгэгдлийн хэсэг нь ямар тохиргоотой, сэтгүүлчийн бүтээлийн дор аливаа заналхийлэл, үзэн ядалт агуулсан сэтгэгдэл байгаа эсэхийг хянаж, шаардлагатай арга хэмжээг авах. Зарим тохиолдолд аливаа бүтээлийг нийтлэхдээ уншигчдаас сэтгэгдлийг нь ил бичих зарчмаар бус, зөвхөн и-мэйлээр санал бодлыг нь хүлээн авах байдлаар тохируулах зэрэг өргөн боломж байдгийг судалж хэрэгжүүлэх.
- Танай редакцын хэн нэгэн сэтгүүлч үзэн ядалт, доромжлолын бай болсон бол энэ асуудал давтагдах өндөр магадлалтай. Тиймээс редакцдаа сургалт авах, дахин үзэн ядалтын бай болсон тохиолдолд ямар арга хэмжээ авах тухай заавар, зөвлөмжийг тодорхой

- болгох хэрэгтэй.
- Мэдээллийн нууцлал болон аюулгүй байдлын талаар сэтгүүлчиддээ зөвлөгөө, сургалт өгч, хамтран ажилла.
- Үүсэн нөхцөл байдлыг зөвөөр үнэлж, эрсдлийг тооц. Тухайн үзэн ядалт, гутаан доромжлол нь хүч хэрэглэх заналхийлэл агуулж уу, сэтгүүлчид чинь халдах магадлал бий юу, энэ асуудлыг цагдаад мэдэгдсэн нь дээр үү зэргийг ярилцаарай. Мөн сэтгүүлчдээ тухайн нөхцөл байдалтай холбоотой бүхий л баримтын архивыг үүсгэхийг зөвлөж, анхааруулах.
- Сэтгүүлч, сурвалжлагчийнхаа сэтгэл зүйн нөхцөл байдлыг мэдэрч, сэтгэцийн эрүүл мэндийг анхааран шаардлагатай бол тусламж үзүүлэх нөхцлийг бүрдүүлээрэй.
- Заналхийлэл, үзэн ядалтад өртсөн хүн ихэнх тохиолдолд өөрийгөө буруутгах, хийсэн зүйлдээ эргэлзэж эхэлдэг. Энэ үед нь ажилтандаа өөртөө итгэх итгэлийг өгч, урам зоригийг нь тэтгэж, редакцын зүгээс түшиж тулах болно гэдгийг хэлээрэй.
- Шаардлагатай тохиолдолд сэтгүүлчээ хамгаалж нийтэд байр сууриа илэрхийл. Асуудал олон нийтийн анхаарлыг татсан бол тэдэнд редакцынхаа зарчим, үйл хэргийг тайлбарлан таниул.

- Редакцын хамт олондоо үзэн ядалт, заналхийлэлд өртсөн хэн нэгэндээ хэрхэн тусалж болох тухай ярилцахын зэрэгцээ редакцын хамт олны нууцыг яаж хадгалах, хамгаалахаа илэрхийл.
- Танай байгууллагад сошиал медиа хэрэглээний зөвлөмж, журам бий юу, ажилтнууд тань хувийн нууцаа хангалттай хамгаалж чадаж байгаа юу, хэрэв хэн нэгэн нь сошиал дайралтад өртвөл түүнийг хэн хариуцаж, шийдвэрийг зохион байгуулах вэ? Энэ бүхнийг тодорхой болгосон дүрэм, дотоод журам хэрэгтэй.



Редакцын хамт олонд зөвлөх нь:

- Хамт ажилладаг сэтгүүлчийн хувьд түүнд тусламж хэрэгтэй эсэхийг асуугаарай. Мөн үзэн ядаж, гутаан доромжилсон сэтгэгдлүүдийг шүүж, и-мэйлээ эмхлэхэд нь туслалцаа хэрэгтэй эсэхийг лавлаарай.
- Хэрэв хамт ажилладаг сэтгүүлчийн чинь профайлд заналхийлэл болон гутаан доромжилсон коментууд сошиал медиагаар ирсээр байвал тэр бүрийг репорт хийж тухайн платформын ямар журмыг зөрчиж байгааг мэдээлээрэй.
 - Зүгээр л хамт ярилцах нь хүртэл энэ үед дэмтэй байдаг. Өмнө нь үзэн ядалтад өртөж, олон тооны

доромжилсон сэтгэгдэл авч байсан сэтгүүлчдийн нөхцлийг харвал хамт олонтойгоо ярилцах, хуваалцах нь тус болсон байдаг.

- Хэрэв танайд ажилладаг гэрээт нийтлэлч, сэтгүүлч бол тэднийг кофенд урьж ярилцаарай. Тэдний хувьд нийтлэл, нэвтрүүлгээ ганцаараа бэлтгэж ажилладаг тул асуудал тулгарсан үед ярилцах хамт олон байдаггүй. Тиймээс таны тус хэрэгтэй.
- Шаардлагатай бол хамтран ажиллагчаа дэмжсэн, эерэг сэтгэгдлүүдийг илээр, олон нийтэд харагдах байдлаар бичиж үлдээ. Троллууд дайрч буй сэтгүүлчийг нь дэмжих хамт олон, хүмүүс байдгийг мэдээд хүч нь сулардаг.
- Интернэт бол албаны төдийгүй хувийн ажлаа хурдтайгаар амжуулж, бусадтай сүлжилдэх боломжтой олон нийтийн талбар. Тиймээс нэг удаагийн дайралтаас болж сошиал медиагаа бүрмөсөн хаах шаардлагагүй гэдгийг зөвлөөрэй.
- “Интернэт дэх зүйлийг тоох хэрэггүй” гэж битгий үл тоомсорлоорой. Цахим халдлага нь бодит үр нөлөөтэй буюу бусдын нэр хүндийг сэвтээж, аюулгүй байдалд нь заналхийлж бас сэтгэл санаанд нь ч нөлөөлдөг. Тиймээс аль болох ярилцаж, тайвшрахад нь туслах хэрэгтэй.



Хоёр. СЭТГҮҮЛЧ, СУРВАЛЖЛАГЧ СОШИАЛ МЕДИА ОРЧИНД БИЭЭ АВЧ ЯВАХ НЬ

Сошиал медиа буюу нийгмийн мэдээллийн хэрэгсэл нь сэтгүүлчийн үйл ажиллагааны салшгүй хэсэг бөгөөд олон нийттэй холбоо тогтоох, шуурхай, чухал мэдээллийг олж авах төдийгүй шинэ орчны хүлээн авагчидтай холбогдох боломжийг олгож байгаа юм. Гэхдээ нэг л буруу алхам нь хувийн болоод мэргэжлийн байдлын ялгааг бүдгэрүүлж бусдад буруу ойлголт төрүүлэх нь бий. Тиймээс фэйсбүүк, твиттер, ютүб, инстаграм, гүүгл плас зэрэг сайт, аппликейшнийг ашиглахдаа мөрдлөг болгох зөвлөмжийг хүргэж байна.

Сэтгүүлч, сурвалжлагчийн хувьд таныг дараах үйл ажиллагаандаа анхаарахыг санал болгож байна:

1. Хэдийгээр редакцын нэрийг агуулаагүй байж болох ч та хувийн хуудсаараа ажлын холбогдолтой харилцаа үүсгэж, мэдээлэл цуглуулж олон нийттэй харилцдаг бол. (@Tsetseg Badam гэсэн хаягтай ч, үүгээрээ ажил хэргийн харилцаа өрнүүлдэг бол)
2. Редакцын нэрийн доорх сэтгүүлч, сурвалжлагч, хөтлөгч/нэвтрүүлэгч, ба редакторын хуудас (@Tsetseg CNA, @Tsetseg X Сонин)
3. Брэнд хөтөлбөр, нэвтрүүлэг, хэвлэмэл болон онлайн булан, нийтлэлийн албан ёсны сошиал медиа хуудсуудыг хөтлөх (@Өглөөний шоу, @Хөгжмийн хөтөлбөр @Авторын булан)



Сошиал медиагийн хувийн хэрэглээ:

а) Хамгийн товчоор “Тэнэг зүйл бүү хий”. Эфирт, ажлын байранд, сошиал орчинд ч хүмүүс таныг тухайн редакцын сэтгүүлч л гэж харна. Тиймээс редакцын бодлогоос зөрүүтэй араншин гаргах хэрэггүй.

б) Direct Message, Private Message болон хүлээн авагчийн тодорхой тохиргоотой байлаа ч оруулж, явуулж байгаа мэдээллээ үргэлж нягталж, болгоомжтой байх нь зүйтэй. Учир нь тухайн мэдээллийг олж авахыг хүсвэл тийм ч хэцүү биш байдаг. Тиймээс хэчнээн “хувийн, нууц” тохиргоотой ч оруулсан мэдээллийг тань бүх хүн үзнэ гэдгийг анхаар.

в) Хэрэв таны сошиал хаягт танай редакцын нэр ороогүй, өөрийн нэрээр байдаг бол заавал оруулах шаардлагагүй. Гэхдээ тухайн хаягаар ажил хэргийн холбогдолтой харилцаа өрнүүлдэг бол нэрэндээ редакцийн нэр дурьдахгүй ч, танилцуулга (Bio) хэсэгтээ “Views are my own” (Энд байгаа постууд нь миний хувийн үзэл бодол болно) гэсэн тайлбар зайлшгүй оруулах ёстой.

г) Улс төрийн үзэл баримтлалынхаа талаар сошиал орчинд дурьдах хэрэггүй. Мөн аливаа зүйлийн талаар хангалттай мэдээлэлгүй үедээ сошиал орчинд дуугарах шаардлагагүй. Wikipedia төдийхнийг эх сурвалжаа

болгохыг хатуу хориглоно. Хамтран ажиллагсадаа олны өмнө шүүмжилж, редакцын судалж байгаа чухал сэдэв, асуудлыг дэлгэх ёсгүй.

д) Сошиал орчин дахь “Найзууд”, “Дагагчид” зэргийг харах боломжтой байдаг тул бусдад ямар нэг онцгой ойлголт өгөхүйц байдлаар бүртгэл хийхгүй байх. Шаардлагатай үед тэнцвэртэй байдлыг хадгалах нь чухал. Нөгөө талаас “Like”, “Favorite” дарж байгаа постуудаа ч мөн анхаарах ёстой.

е) Батлагдаагүй мэдээлэл, цуурхлыг түгээх вий гэдгээ бодолцоно уу. Ялангуяа, шуурхай мэдээллийн үед. “Сошиал орчинд шуурхай байх гэж батлагдаагүй мэдээлэл цацсан ч түүнийгээ устгачихаж болно” гэж эндүүрэх тохиолдол бий. Харамсалтай нь, таны бичсэн батлагдаагүй мэдээллийг зураг болгон хадгалаад таны нэр хүндэд халдах боломжтой гэдгийг бүү мартаарай.

ж) Сошиал орчинд хүмүүстэй харилцахдаа болгоомжтой байж эелдэг бай. Хэн нэгэн бүдүүлэг авирлаж, шүүмжлэлтэй хандсаны хариуд шууд уурлаж, бухимдах хэрэггүй. Block хийх түүнтэй адилтгах арга хэмжээ авах нь бүр ч зохисгүй юм.

з) Хэрэв өөрийн сошиал хуудас, блогтой бол тэр тухайгаа редакцид мэдэгдэнэ үү. Хэдийгээр таныг хориглохгүй ч, байж болох эрсдлийн талаар харилцан ярилцах нь редакцын

хамт олонд тустай.

i) Хэдийгээр хувийн хуудас чинь ч түүнд гэр бүлийнхээ зураг, гэрийнхээ байршил, хүүхдүүдийнхээ зураг, мэдээллийг оруулахаас аль болох татгалзах нь зүйтэй. Учир нь энэ эргээд эрсдэлд орох нөхцлийг бүрдүүлж болох юм.



Редакцын нэрийн доорх сэтгүүлч, сурвалжлагч, хөтлөгч/нэвтрүүлэгч, ба редакторын хуудас

a) Редактор, нэвтрүүлэгч, хөтлөгч, сурвалжлагчдын албан ёсны хаягтай социал медиа үйл ажиллагаа нь тэдний редакцын үйл ажиллагааны нэг хэсэг гэж тооцогддог.

b) Хэрэв албаны хаяг мөн бол редакцын бодлогын хүрээнд ажиллах ёстой. Нэгэнт нэр тань редакцын нэрийг агуулж байгаа бол танилцуулгад “Энд байгаа үзэл бодол нь миний хувийнх болно” гэж бичээд ч нэмэргүйг анхаараарай.

c) Албаны хаягтай байх нь зөвхөн ажлынхаа тухай ярина гэсэн үг биш юм. Харин ч эсрэгээрээ социал орчинд “хэн нэгэн” байх зайлшгүй шаардлагатай. Гол нь олон нийт таныг тухайн редакцын хөтлөгч, сурвалжлагч, редактор гэж хүлээж авна гэдгийг үргэлж санах ёстой



Брэнд хөтөлбөр, нэвтрүүлэг, булан, нийтлэлийн албан ёсны социал медиа хуудсуудыг хөтлөх

a) Нийтлэл, нэвтрүүлгийн албан ёсны хаягийг маш сайн нухацтай төлөвлөж ажиллах ёстой. Хүртээмж, үр нөлөө, редакцын бодлогыг тооцолгүйгээр үйл ажиллагаа эхлэх нь зохимжгүй юм. Тиймээс социал медиа багийнхан ба редакцын хамт олонтой ярилцаж шийдэх шаардлагатай.

b) Албан ёсны социал медиа хаягийн алтан дүрэм бол ямар ч постыг оруулахынхаа өмнө зайлшгүй дахин нягталж, “өөр” нүдээр харж, бодолцох юм.

c) Олон нийтийн зүгээс илгээсэн зурвас, мессежийг редакц, редакторт мэдэгдэж, зохистой хариуг хурдан өгч байх ёстой. Эргэх холбоог алдагдуулж болохгүй.

d) Албан ёсны социал медиа хаягийг хариуцаж байгаа бол аюулгүй байдлыг хангаж, хариуцлага хүлээнэ. Гадны этгээд нэвтрэх, хакердах гэхчлэн бүхий л эрсдэлээс хамгаалах ёстой. Нууц үгээ аль болох ойрхон сольж, түүнийг тэмдэглэж хадгалах, нууц үгээ э-мэйл, чатаар илгээх зэргийг хатуу хориглоно.

e) Аюулгүй байдал, эрсдлээс хамгаалахын тулд хаягаараа нэвтрэч орсон аливаа төхөөрөмжид нууц үгийг сануулахгүй байх, төхөөрөмжөөс холдох үедээ заавал log out хийж гарч байхыг анхаарна.



Шуурхай мэдээллийн үед

- a) Хэвлэл, мэдээллийн байгууллагын хувьд хурдыг давах нэг үзүүлэлт нь үнэн, бодит байдал юм. Тиймээс социал медиад оруулахын өмнө заавал нягтал.
- b) Өөрийн социал хаягаар шуурхай мэдээлэл ирсэн тохиолдолд эхлээд хариуцах албанд мэдэгдэнэ үү.



Хэрэглэгчийн оруулсан агуулгыг ашиглах /UGC – User-generated content/

- a) Видео болон бусад социал медиа орчинд байгаа агуулга нь “Public” тохиргоотой бол ашиглахад асуудалгүй. Гэхдээ тодорхой, үнэн бодит мэдээлэл түгээх зорилгын хүрээнд эзнээс нь зөвшөөрөл авахыг эрэлхийлэх нь ёс зүйн хувьд зохимжтой юм. Мөн энэ үед тухайн агуулгыг постолсон хүн нь эх зохиогч биш байх тохиолдол байдаг тул, хэнд хандах ёстойгоо тодорхой болго.
- b) Мэргэжлийн бус эх сурвалж бидэнтэй агуулгаа хуваалцаж байгаа нь бидний ажилд тус болж буй хэлбэр гэж үзэн хүндэтгэлтэй хандах нь зүйтэй. Тиймээс бүтээлд эх сурвалжийн нэрийг дурьдах ёстой. Харин тэдний аюулгүй байдал болон бусад эрсдэлээс сэргийлэх шаардлагатай тохиолдолд редакцын хамт олонтой ярилцаж шийднэ.
- c) Байнгын мэдээлэл авдаг хэрэглэгчидтэй холбоо тогтоож болно. Гэхдээ тэднийг эрсдэлтэй алхам хийж аюултай нөхцөлд зураг, дүрс авах зэргийг дэмжиж огт болохгүй.

Дээрх зөвлөмжүүдэд шуурхай мэдээ, мэргэжлийн биш хүмүүсийн социал орчинд түгээсэн мэдээлэл ба хэрэглэгчийн бүтээсэн агуулгыг хэрхэн ашиглахыг тусгасан болно.



Гурав. СЭТГҮҮЛЧ СОШИАЛ МЕДИАД МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХДЭЭ ХУВИЙН БОЛОН РЕДАКЦИЙН БАЙР СУУРИЙГ ЯЛГАХ

Твиттер, фэйсбүүк, инстаграм зэрэг нийгмийн мэдээллийн хэрэгсэл нь сурвалжлагчийн мэдээллээ түгээх, хүргэх онцгой суваг боловч хувь хүний хувьд уншигчтайгаа холбогдоход тодорхой зааг баримтлах шаардлагатай юм. Сүүлийн үед сэтгүүлч, сурвалжлагчдыг өөрийн хувийн үзэл бодлоо экаунт болон пэйжээрээ илэрхийлэх, уншигчдын сэтгэгдэлд хэрхэн хандах зэргийг редакаас тусгайлан зөвлөх болжээ. Түүнчлэн сэтгүүлчдийг хувийн болон редакцийн байр суурийг ялгаж, сошиал орчинд “хоёр нүүр” гаргахгүй байхыг анхааруулж байна.



Юу хийдгээ дэлгэрэнгүй ярихгүй байх

Хамтран ажиллагсад болон редакцын нэр хүндтэй холбоотой мэдээллийг пост хийхийг хориглодог. Редакцын цахим хуудас болон өөрийн сошиал медиа хаяг болон пэйждээ нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэх явц, контент хөгжүүлэлт болон мэдээний өрөөтэй холбоотой пост хийхээс зайлсхийх учиртай. Түүнчлэн хамтран ажиллагч болон ажлын нөхцөл байдлынхаа талаар сэтгэгдэл нийтлэх нь зохисгүй.

Өөрөөр хэлбэл нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэж буй сэдэв, мэдээний өрөөний ажиллаж байгаа агуулга болон тэдгээрийн эх сурвалжийн талаар пост хийхдээ редакцын хамт олонтой зайлшгүй ярилцах шаардлагатай. Энэ зөвхөн редакцын нэр бүхий хаягтай хүмүүсээс гадна агуулгыг боловсруулахад оролцож буй эвлүүлэгч, дизайнер гээд бүх хүнд хамаатай юм.



Уншигч, үзэгчтэйгээ маргах хэрэггүй

Сэтгүүлч болон сурвалжлагчид өөрсдийн бэлтгэсэн мэдээ, мэдээллийг сошиал орчинд редакторын байр сууринаас тайлбарлан, мэдээлэх ёсгүй. Ялангуяа, редакцын цахим хуудас болон сошиал хуудсууд дахь сэтгэгдлүүдэд хариу өгөх, сурвалжлагын талаар маргаж, мэтгэж болохгүй. Учир нь нийтлэл, нэвтрүүлгийн сэтгэгдэл хэсэг нь уншигч, үзэгчид өөр хоорондоо хэлэлцэж, ярилцах орон зай

болохоос сэтгүүлч, редакторууд оролцоод байх талбар биш.



Хувийн үзэл бодлоо илэрхийлэхгүй байх

Сошиал медиад хүч, нөлөөтэй байхад хувь чанарын илэрхийлэл мэдээж хамгийн чухал. Хүлээн авагчидтайгаа харилцдаг хувь хүний илэрхийлэл болох нь мэдээллээ хүргэхэд илүү хялбар, найдвартай сэтгэгдэл төрүүлнэ. Гэхдээ ингэлээ гээд аливаа мэдээ, сурвалжлагадаа хувийн ашиг сонирхлоо илэрхийлэх, хийсэн агуулгынхаа дараа өөрийн хувийн байр суурийг нэмж тайлбарлах зэрэг нь эрсдэлтэй алхамд тооцогддог.

Тухайлбал, Нью-Йорк Таймс сонины хувьд сэтгүүлчид сошиал медиа орчинд улстөрийн үзэл бодлоо илэрхийлэх, нэр дэвшигчийг дэмжих болон редакцын зарчимд үл нийцэхүйц бусдыг гутаан доромжилсон пост хийхийг хориглодог.



Олон нийтийг талцуулсан асуудлаарх аливаа “private” болон “secret” тохиргоотой группт элсэхгүй байх

Аливаа нам, эвсэл, хөдөлгөөнтэй холбоотой группт элсэж, байр сууриа илэрхийлэх нь зохимжгүй. Түүнчлэн энэ төрлийн эвент/үйл ажиллагаанд очихоо сошиал медиад бүртгүүлж зарлах хэрэггүй. Хэрэв сурвалжлах зорилгоор очих бол үйл явдлыг угтаж болон дараа нь юу постлохдоо няхуур хандах хэрэгтэй.



Дөрөв. СЭТГҮҮЛЧ ХУУРАМЧ МЭДЭЭЛЛИЙГ ЯЛГАЖ ТАНИХ ЧАДВАРТАЙ БАЙЖ, ХУУРАМЧ МЭДЭЭЛЛИЙГ ТҮГЭЭХГҮЙ БАЙХ

Дижитал эрин үед технологи хөгжихийн хэрээр цахим орчинд хуурамч мэдээлэл түгэх нь элбэг болжээ. Хуурамч мэдээллийг дараах байдлаар ангилж ялгаатай хандаж байна.

- Disinformation — гэдэг нь зориуд бэлтгэсэн хуурамч мэдээ бөгөөд хэн нэг хувь хүн, олон нийт болон байгууллага, улсад хохирол учруулах зорилготой байдаг.
- Misinformation — ямар нэг хохирол учруулах зорилгогүй, санамсаргүй түгээсэн хуурамч мэдээ
- Mal-information – бодит үнэн мэдээлэлд суурилсан бөгөөд түүнийг бусад хувь хүн, олон нийт, байгууллагад хохирол учруулах зорилгоор дэвэргэн түгээх зэрэг хэлбэрүүд бий.



Тэгвэл мэдээллийг нягтлах нь яагаад чухал вэ?

Өрнөж буй үйл явдал, аливаа үзэгдлийг ажиглаж, сурвалжилж, эх сурвалжаас тодруулж, баримтыг олж авах, тэгээд нийтэд мэдээлэх. Мэдээжийн юм шиг энэ үйл явц нь орчин цагт илүү ярвигтай болжээ. Бидэнд байгаа баримт, мэдээлэл нь баталгаатай эсэх, судалгаа, илтгэл нь мэргэжлийн зэргээс шалтгаалаад үл ойлголцол, хор хохирол цаашлаад түүхийн нэгэн хэсгийг буруу зураглан үлдээх эрсдэлтэй. Тиймээс аливаа боловсруулаагүй мэдээллийг сэтгүүл зүйн мэдээ болгон бэлтгэхдээ дахин дахин нягтлах зайлшгүй шаардлагатай болоод байна. Ингэснээр бид баримтыг хов жив, цуурхлаас ялгаж, нийтийн анхаарлыг хуурамч зүйлд татах гэсэн оролдлогоос сэргийлж, цаашлаад хэн нэгний нуухыг хүссэн зүйлийг харин илчлэн гаргах боломжтой юм.



Баримтаа нягталсан уу?

Баримтыг нягтлахдаа хамгийн түрүүнд өөрөөсөө эхлэх хэрэгтэй. Та тухайн үйл явдал, үзэгдэлтэй холбоотой сэдвийг сайн мэдэх үү, энэ талаар мэргэшсэн, ядаж тогтмол сонирхдог, сурвалжилдаг сэтгүүлч мөн үү, Танд тодорхой таамагласан үр дүн, нөлөө бий учраас сонирхож байгаа юу, эсвэл толгойдоо аль хэдийнэ гарчгийг нь бодож олчихоод зөвхөн түүндээ тохирсон баримтыг эрээд байгаа юм биш

биз. Хэрэв тийм бол илүү хөндлөнгийн байр сууринаас хандаж, нягтлахдаа анхаарах хэрэгтэй. Мэдээж өөрийн чин эрмэлзэл, сонирхолд тулгуурласан, сайн мэдэх зүйлээ сурвалжлах нь хялбар ч мэргэжлийн үйл ажиллагаандаа тэрхүү итгэл, сэтгэлээ хэзээ ч бат үнэмшил болгож болохгүй.



Дор хаяж хоёр эх сурвалжаар нягтлах

Зарим редакцад зайлшгүй хоёр эх сурвалжаар баталгаажуулахыг мөрдлөг болгосон байдгийг бид мэднэ. Түүнчлэн онлайн эх сурвалж нь ердөө нэг л бүлэгт тооцогддогийг санаарай. Тиймээс зайлшгүй өөр найдвартай эх сурвалжаар баталгаажуулах нь зүйтэй. Зарим тохиолдолд эх сурвалжаа зайлшгүй нууцлах шаардлагатай ч, ямар ч гэсэн өөрийнхөө хувьд тухайн эх сурвалж нь найдвартай үгүйг нягтлаарай. Мөн редактортаа тухайн эх сурвалж нь найдвартай, түүний хангах мэдээлэл нь үнэн, зөв гэдгийг ойлгуулах хэрэгтэй.



Мэдээллийн агентлагууд, хэвлэлийн мэдээнд бүрэн найдаад хэрэггүй

Заримдаа мэдээллийн агентлаг, албан мэдээ зэргийг шуудхан хуулаад тавих нь бий. Тэд мэдээж албан ёсных, бас заримд нь мөнгө төлж тогтмол мэдээллийг нь бид авдаг. Гэсэн хэдий ч заримдаа тэд ч бас алдаж мэднэ. Үүнийг нягтлалгүй, шууд

“copy & paste” хийчээд дараа нь хүлээн авагчдаасаа уучлалт гуйх нь хүсэх зүйл биш. Тиймээс тэдний итгэлийг хадгалж, найдвартай мэдээллийн хэрэгсэл нь байя гэвэл зайлшгүй шалгах нягтлах хэрэгтэй. Мөн хэвлэлийн албан мэдээ нь гол төлөв үйл явдалд оролцогч, хамаарал бүхий талуудын нэг талын байр суурь байдаг учраас тэд юу нуухыг “оролдож” байна, тэд юуг хэлэв гэдгийг нягтлах хэрэгтэй.



Сэтгүүлч хэнд итгэж болох вэ?

Товчхондоо хэнд ч биш. Ямар ч мэдээллийг шалгаж үзэлгүйгээр шууд хүлээн авах хэрэггүй. Өөрт ирсэн аливаа мэдээлэлд заавал “үл итгэсэн” байдлаар хандаж нягталж үз. Мөн хэдийгээр өмнө нь үнэн бодит мэдээллээр хангаж байсан эх сурвалж яриа өгсөн ч, түүнийг нь энэ удаад лавлаад асуухад гэмгүй. Учир нь энэ бол сэтгүүлчийн хувьд хийх л ёстой үйлдэл, ажлынх нь нэг хэсэг болохоос хэн нэгэнд сэтгэлээ нээж итгэхгүй байгаа хэрэг биш юм.



Шуурхай мэдээллийн үед яах вэ?

Хоёр эх сурвалжаар баталгаажуулах дүрмээ зөрчих тохиолдол бий. Шуурхай мэдээлэл аль нэг агентлагаас ирж, түүнийг лавлах, шалгах цаг хугацаа байхгүй байж болно. Энэ үед редактортаа хандах хэрэгтэй. Түүнчлэн “тухайн мэдээллийн агентлагийн мэдээлж байгаагаар”

гэж эх сурвалжийг тодотгон зааж өгч болно. Зайлшгүй тохиолдолд “бид энэ мэдээллийг бүрэн баталгаажуулаагүй байна” гэдгээ хэлж болно.



Удирдлагаас өгсөн даалгавар

Таны редактор, эсвэл хэн нэг удирдлага тань ямар нэг сэдэв, баримтын араас хөөхийг онцгойлон даалгасан уу? Тийм бол яагаад гэж асууж үзсэн үү? Яагаад танд тэр сэдвийг өгөв, ямар учраас тухайн сэдвийг зайлшгүй сурвалжлах шаардлагатай болов? Удирдлага тань л өгсөн учраас энэ бүхэн үнэнд нийцнэ, олон нийтийн эрх ашигт таарна гэсэн үг биш. Тиймээс энэ тохиолдолд ч эргэлзэж, нягтлахаа мартаж учиргүй.



Тав. СЭТГҮҮЛЧ ЦАХИМ ОРЧИНД ҮЗЭН ЯДАЛТЫН ҮГ ХЭЛЛЭГИЙГ АШИГЛАХГҮЙ БАЙХ

“Hate Speech” буюу үзэн ядах үг хэллэг бүхий агуулга цахим орчинд маш хурдтай, өргөн хүрээг хамран тархаж байгааг “Цахим сайтууд дахь үзэн ядах үг хэллэг”¹ судалгаанд дурьджээ. Улмаар хэдий тийм боловч үзэн ядах үг хэллэгийг тарааж, түгээхийн эсрэг ямар нэг ажил, санаачилга манай улсад байхгүй байна. Тиймээс энэ талаар илүү нарийн судлахын зэрэгцээ олон нийт болон мэргэжилтнүүдийн ойлголтыг сайжруулах, үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх чиглэлд хэвлэл, мэдээллийн оролцоог хангах нь чухал юм.

“Цахим сайтууд дахь үзэн ядах үг хэллэг” судалгааны тайланд дурьдсанаар үзэн ядах үг хэллэгийг тодорхойлохдоо:

- Арьс өнгө, шашин шүтлэг, хүйс, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл зэрэгт нь үндэслэн хэн нэгнийг, эсхүл хэсэг бүлэг хүнийг үзэн ядах хандлага гаргасан, эсхүл тэдний эсрэг хүчирхийллийг хөхүүлэн дэмжихүйц олон нийт рүү чиглэсэн үг хэллэгийг хэлнэ. /Кэмбридж тайлбар толь бичиг/
- Арьс өнгөний үзэл, сенофоби, антисемитизм болон бусад үндэсний үзэл, үндсэрхэг дээрэнгүй үзэл, мөн цөөнхийн болон цагаач гаралтай хүмүүсийн эсрэг дайсагнал болон ялгаварлан гадуурхлыг тараах, өдөөх, сурталчлах, зөвтгөх бүх төрлийн илэрхийллийг ойлгоно. /Европын холбооны сайд нарын зөвлөл/ гэжээ.

Тэгвэл сэтгүүлч, сурвалжлагчид үзэн ядах үг хэллэг түгээхээс хэрхэн сэргийлэх вэ? Ялангуяа, аливаа улс орон, тэдгээрийн соёл, бүлгүүд хоорондын ялгаатай байдлын улмаас үзэн ядалтын үг хэллэг нь яг энэ хэм хэмжээнд хүрвэл ингэж нөлөөлнө гэж ерөнхийлөн тодорхойлоход бэрхшээлтэй байдаг.

Тиймээс газар дээр нь сурвалжилж, ярилцаж буй сэтгүүлчийн хувьд хэн нэгний илэрхийлэх гэсэн санаанд хам,

өргөн утгаар нь (контекст) хандах хэрэгтэй. Түүнчлэн тэдний яг юу гэж хэлснийг биш ямар санаатай хэлэв гэдгийг анхаарах нь чухал. Ингэснээр тухайн үг хэллэг нь бусдыг хор хөнөөлтэй эсэх, ялангуяа үймээн самуунтай үед бусдыг ямар нэг үйл ажиллагаанд уриалж мэдэх үед сэргийлэлт болох юм.

Олон улсын стандартад суурилан Их Британи дахь “Ethical Journalism Network” байгууллагаас сэтгүүлчдэд дараах таван алхамт тестийг боловсруулжээ. Сэтгүүлч, редакторууд мэдээлэл цуглуулах, боловсруулах болон түгээх явцдаа эдгээр асуултыг эргэн санаж үзэн ядалтын үг хэллэг түгээхээс сэргийлэх боломжтой.



Өгүүлэгчийн байр суурь болон статус

Сэтгүүлчдийг ихэвчлэн өдөөн хатгасан яриатай хэн нэгнийг хүлцэж сонссон, яриаг цааш үргэлжлүүлэн түгээсэн зэргээр үзэн ядах үг хэллэгийг тараасан гэж буруутгадаг. Мөн хэвлэл мэдээллээр ярьж сурсан зарчимгүй улстөрчид болон аливаа бүлэг, хөдөлгөөний толгойлогчид дуулиан шуугиантай мэдэгдлийн өдөөн турхирсан үр дагаврыг үл тоон сэтгүүлчдэд ярьж түүнийг нь нийтэлж, нэвтрүүлнэ гэж итгэдэг.

Харин сэтгүүлч, редакторуудын хувьд хэн нэгний хэлсэн хурц илэрхийллүүд нь үргэлж мэдээ болохгүй гэдгийг санаж байх нь чухал. Тэр дундаа өгүүлэгчийн хэлсэн санаа, түүний илэрхийлж буй байр

суурь болон нэр хүндийг харгалзан үзэх хэрэгтэй.

Нэг ёсондоо хэвлэл, мэдээллийнхэн өгүүлэгчийн үг хэл, дурьдаж буй баримт, мэдэгдэж буй санаа зэргийг нарийн анхаарах учиртай.

Үг хэлэх эрх чөлөө нь бүгдийн эрх бөгөөд үүнд улстөрч, олны танил хүмүүс ч ялгаагүй хамаарах хэдий ч энэ нь худал ярих, аливааг гуйвуулан дэвэргэх, бусад хүн, бүлгийг ялгаварлан гадуурхаж, доромжлох хэрэгсэл болох ёсгүй.



Үг хэллэгийн давтамж ямар байгааг нягтлах

Үзэн ядалтын үг хэллэгийг түгээж буй өгүүлэгчийн давтамжийг сэтгүүлчид анхаарах нь чухал. Шуурхай үйл явдлын үед үг алдаж хэлсэн тохиолдол уу, эсвэл үзэн ядах хандлагыг зориуд, олон давтамжтай илэрхийлж байна уу.



Үг хэллэгийг нэвтрүүлэхийн өмнө зорилгыг нь анхаарч үзэх

Сэтгүүлчийн ёс зүйн аливаа код болон үйл явдал, үзэгдэлтэй холбоотой сэдвийн талаар туршлагатай редакторууд хэлсэн үг хэллэг нь аливаа бие хүн, бүлгийг ялгаварлан гадуурхсан, эсвэл хүний эрхэнд харш эсэхийг шуудхан нягтлах боломжтой. Цаашлаад эдгээр нь гэмт хэргийн шинжтэй эсэхийг тодорхойлж болно. Мэдээж зарим тохиолдолд сэтгүүлч, сурвалжлагчид дүрмээс

гадуур “тоглох” нь бий ч, нийтэлж, нэвтрүүлэхийнхээ өмнө эрсдлийг тооцож үзэх шаардлагатай.

Аливаа үг хэллэгийг нэвтрүүлэхдээ өгүүлэгчийн зорилго нь зөвхөн үг хэллэг төдийгүй контекстийн хувьд юу вэ гэдгийг харах хэрэгтэй. Мэдээж санал нийлээгүй хүнийхээ үгийг шуудхан хасах, эсвэл нэмэн дэлгэрүүлж болохгүй ч ёс зүйтэй хандах нь хэзээд хүлээн авагчдад үнэн, бодит ойлголт өгөхөд л нэмэр болдог.

Тэгвэл өгүүлэгчийн ашиг сонирхол юу вэ, энэ яриаг нийтэлж, нэвтрүүлснээр түүнд ямар нэг давуу тал бий болж байна уу? Энэ үг хэллэгийн хохирогч нь хэн бэ, тодорхой бие хүн, бүлэгт хор хохиролтой байна уу гэдгийг шалгаж асууж болох юм.



Агуулга ба хэлбэр

Тухайн хүн гутаан, доромжилсон байдлаар үг хэллэгээ шууд хэлсэн үү, эсвэл тойруулж тийм утга илэрхийлэв үү гэдгийг бид хялбархан мэдэж болно. Түүнчлэн үзэн ядах үг хэллэгийг кафе, зоогийн газар ярилцаж суухдаа хэлэв үү, эсвэл олон нийтийн газар, олны дэргэд хэлсэн үү гэхчлэн олон янзын нөхцөл байдал таарч болно.

Нийтийн жишгээс өөр санаа бодол, үзэл хандлагатай хүн олон бий. Түүнийгээ олон нийтэд илэрхийлэх нь ч гэмт хэрэг биш. Харин тэрхүү үзэл бодол нь бусдыг аливаа хэлбэрээр хохироох, тэднийг үзэн ядаж, ялгаварлан гадуурхахад уриалан дуудсан байвал бид зайлшгүй эргэж харах ёстой.



Энэ үед сэтгүүлчид өөртөө дараах асуултуудыг тавьж болно:

- Энэ хүний яриа, илэрхийлэл аюултай юу?
- Хууль, дүрэм зөрчсөн хэлбэр байна уу?
- Бусдыг үзэн ядаж, өдөөн турхирсан шинжтэй байна уу?
- Мэдээллийн хувьд үнэхээр нийтэлж, нэвтрүүлэхүйц ач холбогдолтой юу?
- Мөн эдгээрийг эшилж, түгээснээр та өөрөө ч бас ямар нэг хууль, дүрэм зөрчсөн эрсдэлд орох магадлалтай юу?



Эдийн засаг, нийгэм, улстөрийн нөхцлийг харгалзах

Нийгмийн хуваагдал, зөрчил ихтэй улстөрийн аливаа нөхцөл байдлын үед өдөөн турхирсан үг хэллэг, утга илэрхийллийг нийтэлж, нэвтрүүлэхдээ болгоомжтой хандах ёстой. Тухайн үеийн олон нийтийн уур амьсгалыг сэтгүүлч мэдэрч сурах нь зайлшгүй юм. Улстөрийн сонгуулийн кампанит ажлын үеэр олон нийтийн анхаарлыг татахын тулд улстөрчид сөргөлдөж, өдөөн хатгасан ярианууд хийх нь бий. Энэ үед тэдний

үгийг шууд дамжуулах биш тэнцвэртэй, баримтад тулгуурласан байгаа эсэхийг нягталж, нөхцөл байдалтай хэрхэн уялдаж байгааг харах нь зүйтэй.

Түүнчлэн нийгмийн бүлгүүдийг ялгаварлан гадуурхах нь элбэг тохиолддог. Арьс өнгө, үндэс угсаагаар ялгаварлан гадуурхсан үг хэллэгийг нэвтрүүлэхдээ өөрийн орны нийгэм, соёлын нөхцөл байдалтай уялдаатайгаар авч үзэж, нягтлах ёстой. Манай улсын хувьд нутаг ус, эрхэлж буй ажлаар нь хомроглон нэр хоч өгөх тохиолдол олонтаа байсныг “Цахим сайтууд дахь үзэн ядах үг хэллэг” судалгааны тайланд дурьдсан байсан тул үүнийг ч нийтлэл, нэвтрүүлэгтээ харгалзах нь зөв юм.



Нийтлэл, нэвтрүүлгийг түгээхийн өмнө дараах байдлаар шалгаж үзэж болно:

а) Улстөрийн сэдэлтэй үзэн ядалтын үг хэллэг түгээсэн үед сенсаци болгохгүй байхыг эрмэлзэх хэрэгтэй:

- Энэ мэдээлэл үнэхээр ач холбогдолтой юу?
- Өгүүлэгчийн зорилго, санаа юу вэ?
- Нийтэлж, нэвтрүүлснээр ямар үр нөлөө бий болох вэ?
- Үүнийг нэвтрүүлснээр өдөөн турхирах, хүчирхийлэлд уриалан дуудах нөхцөл болох уу?
- Энэ яриа нь баримтад тулгуурласан уу, батлагдаж байна уу?

б) Асуудалтай материалыг боловсруулах явцдаа нийтлэх гэж яарах хэрэггүй. Хэдхэн хором бодоод үзээрэй:

- Бид хэвшмэл ойлголт, улиг болсон үзэл хандлагаас сэргийлж чадсан уу?
- Бид зайлшгүй хариулт авах, олон талт асуулуудыг тавьсан уу?
- Бид хүлээн авагчид ямар мэдрэмж авахыг бодож үзсэн үү?
- Үг, хэллэг нь нийтэд дамжуулахад зохимжтой байна уу?
- Зураг, дүрслэл нь хүчирхийлэл, ёс бус илэрхийллийг тусгаж уу?
- Эх сурвалжууд тань олон талын байр суурь, дуу хоолойг тусгаж чадсан уу?
- Редакцын болон ёс зүйн зарчимтай харшлах агуулга бий юу?

с) Мэдээж хамгийн сүүлд илүүдэхгүй нэг зүйл бол:

- Одоог хүртэл эргэлзээ төрж байна уу?
- Хамтран ажиллагчиддаа нэг уншуулж, харуулж үзэх үү?

СЭТГҮҮЛ ЗҮЙН ЁС ЗҮЙН ФОРУМ 2017

УРИАЛГА

Ардчилсан нийгэм дэх сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн байгууллагын хариуцлага өсөн нэмэгдсээр байна. Энэхүү хариуцлагынхаа хүрээнд иргэдээс сонгогдсон төрийн албан тушаалтнууд эрх мэдлээ, бизнесийн бүлэглэлүүд өөрсдийн ашиг сонирхлоо иргэд, олон нийтэд хохиролтойгоор хэтрүүлэн ашиглаж байгаа эсэхийг анхааралтай ажиглах, тандан хянах, олон нийтэд бодит байдлыг мэдээлэх хэвлэл мэдээллийн чиг үүрэг өөрчлөгдөөгүй хэвээр байна. Хэвлэл мэдээллийнхэн аливаа ашиг сонирхлоос хараат бус, чөлөөтэй байх тохиолдолд л энэхүү чиг үүргээ олон нийтийн өмнө хариуцлагатай хэрэгжүүлж чадна. Өнөөдөр эзэд, өмчлөгчдийн хувийн ашиг сонирхолд хөтлөгдөх явдал нь хэвлэл мэдээллийн байгууллагуудын олон нийтийн өмнө хүлээсэн үүргийг хязгаарлах, хэрэгжүүлэх боломжгүй болгох байдалд хүргэж байна. Тиймээс РЕДАКЦИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ хангах эрх зүйн орчинг бий болгох нь чухал гэдгийг онцлон тэмдэглэж байна.

УИХ-аас нэр төр гутаахтай холбоотой зохицуулалтыг Эрүүгийн хуулиас хассан нь хэвлэл мэдээллийн зөрчлийг Иргэний хуулийн хүрээнд шийдвэрлэдэг олон улсын хэм хэмжээнд нийцсэн алхам байсныг бид дэмжсээр ирсэн, өнөөдөр ч бид дэмжиж байна. Харамсалтай нь энэ зохицуулалт Зөрчлийн тухай хуульд буцаад тусгагдсанаас улс төр, эдийн засгийн асуудлыг шүүмжилсэн илэрхийлэлдээ сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагууд өндөр хэмжээний мөнгөн торгууль, захиргааны шийтгэл хүлээж болзошгүй болж байгаа нь тэднийг өөрөө өөртөө цензур тавихад хүргэж, олон нийтийн үнэнийг мэдэх эрхэд сөргөөр нөлөөлөх төдийгүй хэвлэлийн эрх чөлөөнд ч халтай гэж бид үзэж байна.

Монгол Улсад нэгэнт хэвлэл мэдээллийн салбарынхан ЁС ЗҮЙН ЗАРЧИМААРАА алдаагаа засаж залруулах боломжтой болсон энэ цаг үед ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН дээрх заалтыг эргэн авч үзэж, ардчилсан засаглалтай улс орнуудад хүлээн зөвшөөрөгдсөн, олон улсын хэмжээнд туршигдаж, үр дүнгээ өгсөн зөрчлийг шийдвэрлэх ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН арга, механизмаар солихыг ТӨРИЙН ЭРХЭМ ТҮШЭЭДЭД уриалж байна.

Үүний зэрэгцээ ард иргэдийнхээ мэдээлэл олж авах эрхийг хангах, ардчиллыг бэхжүүлэх хариуцлагаа ухамсарлан хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хараат бус байдлыг хүчирхэгжүүлэхэд туслахыг уриалж байна. НУУЦ ЭХ СУРВАЛЖ, РЕДАКЦИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ эрх зүйн зохицуулалтаар хамгаалж, хэвлэл мэдээллийн ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ төлөвшүүлэхэд үзүүлэх та бүхний

ДЭМЖЛЭГИЙГ БИД ХҮСЧ БАЙНА.

Түүнчлэн орчин үеийн технологийн дэвшил, нийгмийн мэдээллийн сүлжээний хөгжил сэтгүүл зүйн нийгэмд гүйцэтгэх үүрэг хариуцлагыг бууруулахгүй. Харин ч эсрэгээрээ нийгмийн сүлжээний мэдээллээс сэтгүүл зүйн бүтээл ялгарч байх ёстой. Хэвлэл мэдээллийнхэн бодит байдалд нийцсэн, тэнцвэртэй мэдээллийг мэргэжлийн сэтгүүл зүйн хэм хэмжээний дагуу боловсруулан хараат бусаар түгээж, үүгээрээ сэтгүүл зүй олон нийтийн үзэл бодол төлөвших үйл явцад чухал нөлөөтэйг хүлээн зөвшөөрч, ЁС ЗҮЙН ЗАРЧИМАА баримталж ажиллахыг нийт СЭТГҮҮЛЧИД, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУДДАА уриалж байна.

Улаанбаатар хот
2017 оны 10 дугаар сарын 03

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗӨВЛӨЛ

СЭТГҮҮЛ ЗҮЙН ЁС ЗҮЙН ФОРУМ 2018

УРИАЛГА

“Мэргэжлийн сэтгүүл зүй ба дижитал эрин үе” сэдэвт сэтгүүл зүйн ёс зүйн хоёрдугаар форумын үеэр Хэвлэл мэдээллийн зөвлөл болон форумд оролцогч цахим сайтуудаас энэхүү уриалгыг гаргаж байна. Үзэл бодолтой байж түүнийгээ илэрхийлэх эрх чөлөөний зааг хязгаарыг дижитал эрин үе, нийгмийн сүлжээний тархалт улам бүр тэлж буй тул мэргэжлийн сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн үүрэг, хариуцлага өсөн нэмэгдсээр байна.

Дижитал эрин үе нь иргэн хоорондын харилцаанд төдийгүй сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаанд эерэг, сөрөг талуудыг зэрэгцүүлэн авчирч байна. Өнөөдөр хэрэглэгч өөрөө мэдээллийг бүтээгч, хүлээн авагч, дамжуулагчийн үүргийг давхар гүйцэтгэх болсноор мэргэжлийн сэтгүүл зүйн чанар чансаа, ёс зүйн асуудал хурцаар хөндөгдөх болов.

Түүнчлэн мэдээллийн талбарт иргэдийн оролцоо нэмэгдэж, мэргэжлийн сэтгүүл зүй ба нийгмийн мэдээллийн сүлжээний зааг ялгаа бүдгэрч байна. Энэ цагт сэтгүүл зүйн салбарынхан ёс зүйн дүрэмгүй нийгмийн сүлжээнийхнээс ялгарах гол чиг шугам нь ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧИМ бөгөөд үүгээрээ нийгмийн сүлжээнд ч үлгэрлэн манлайлахыг НИЙТ СЭТГҮҮЛЧИДДЭЭ уриалж байна.

Цахим орчинд хэрэглэгчид нэрээ нууцлах эсвэл нэрээ нууцалсан мэт харагдах боломжтой учраас хүн ёсны харилцаанаас давж дур зоргоор аашлах байдал руу хальтирч байна. Үүнийг дагаад хүний нэр төрийг гутаан доромжлох, хувийн орон зай, хувь хүний нууцад халдах, худал мэдээлэл тараах, хэн нэгэн эсвэл бүлэг хүн рүү зорилготойгоор сөрөг хандлага түгээх зэрэг олон сөрөг үр дагавар бий болгож, улмаар үзэл ядалтаас үүдсэн гэмт хэрэг рүү хөтлөх эрсдэл дагуулж байна.

Иймд нийгмийн хэвлэл мэдээллийн нөлөөнөөс үүдэн улам бүр тархаж буй ёс бус үг хэллэгүүд, худал мэдээллийн эсрэг сэтгүүлчид мэргэжлийн үйл ажиллагаагаараа ялгарч нийгмийн сүлжээнд өөрийн болон бусдын ханыг ёс зүйтэй хэрэглэх РЕДАКЦИЙН ДОТООД ДҮРЭМ, ЖУРМЫГ мөрдөж эхлэхийг зөвлөж байна.

Мэдээллийг нягтлан шалгах ажлыг редакц бүр, сэтгүүлч бүр өдөр тутмын ажилдаа хэвшүүлэх, хэрэглэгчдийнхээ мэдээлэлтэй харилцах суурь боловсролд редакцын зүгээс иргэний нийгмийн байгууллагуудтай ХАМТЫН АЖИЛЛАГААГ

эхлүүлэхийг чухалчилж байна.

Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт нь мэргэжлийн сэтгүүл зүйн чанарын баталгаа болох тул Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлэхэд редакцуудад ОЙЛГОЛЦОЛ, ХАМТЫН ДЭМЖЛЭГЭЭ улам хүчирхэгжүүлэхийг уриалж байна.

Улаанбаатар хот
2017 оны 10 дугаар сарын 03
ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗӨВЛӨЛ

ДЭЛХИЙН ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ӨДӨР 2019

УРИАЛГА

2020 оны зургадугаар сард УИХ-ын ээлжит сонгууль болно. Сонгуулийн кампанит ажил болгон мэргэжлийн сэтгүүл зүйд ээлжит сорилт болж, тэр хэрээр өндөр шаардлага тавигддаг.

Сүүлийн жилүүдэд сошиал медиа гэж яригддаг олон нийтийн сүлжээний талбар улам бүр тэлж, иргэдийн мэдээлэл хүлээн авах гол сувгийн нэг боллоо. Олон нийтийн сүлжээ нь тэр чинээгээр онцгой талбар болоод байна. Интернэт орчин нь уламжлалт сэтгүүл зүйтэй харьцуулбал мэдээ, баримтаа нягтлан шалгалгүйгээр түгээх, хувь хүний нэр хүндэд халдах нөхцлийг бий болгож байна.

Нийгмийн сүлжээ эрчтэй тархсан сүүлийн сонгуулиудын сурталчилгааны кампанит ажлын мониторингийг хийсэн ажиглагчид энэ үеэр хэвлэлийн зах зээлийн зарим тоглогчид ёс зүйгээ баримтлахыг гол чигээ болгохгүй байгааг тэмдэглэсэн. Сэтгүүл зүйн мэргэжлийн ёс зүйг баримтлах нь сэтгүүлчийн байнга санаж, мөрдөж байх алтан дүрэм. Энэ дүрэм ямар ч нөхцөлд, тэр тусмаа сонгуулийн кампанит ажлын үеэр ажиглагддаг мэдээллийн ширүүн “дайн”-ы үед ч мөрдөгдөж байх учиртай. Мэдээлэл түгээж байгаа талбараас /уламжлалт мэдээллийн хэрэгсэл болон олон нийтийн цахим сүлжээ/ үл хамааран ёс зүйн зарчмууд мөрдөгдөх учиртай.

Нөгөө талаар хэвлэл мэдээллийн ёс зүй гэдэгт редакцын бэлтгэсэн мэргэжлийн контентийн агуулгаас үзэл суртал /PR/ шингэсэн мэдээллийг тодорхой тэмдэглэн зааглаж, хэрэглэгчийг төөрөгдүүлэхгүй байх зарчим мөн багтана. Хэвлэл мэдээллийн зөвлөл олон нийтийн сүлжээний орчинд ч хуурамч, бодит бус мэдээллийг түгээх, цааш нь дамжуулахгүй байхыг үүргээ гэж үздэг. Энэ үүргээ мөрдөх нь олон нийтийн мэдэх эрхийг хангаж, ардчилсан нийгэмд хэвлэл мэдээлэл өөрийн үүргээ гүйцэтгэж байгаа гэсэн үг юм.

Иймээс Хэвлэл мэдээллийн зөвлөл нь Гомдол хүлээж авах, барагдуулах журамдаа сонгуулийн санал хураалт эхлэхийн өмнө сурталчилгаа шувтрах үед гарсан гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зохицуулалтыг хийлээ. Сонгуулийн сурталчилгаа шувтрах үед хэвлэл мэдээлэл ёс зүйн алдаатай мэдээлэл тараасан эсэхийг хэрэглэгчид мэдэх эрхтэй учраас энэхүү заалтаар Ёс зүйн зарчмаа баяжууллаа. Шинэ заалтад “Хэвлэл мэдээлэл нь сонгуулийн санал хураалтаас өмнө буруутгагдсан этгээдийг тайлбар хийх боломжгүй хугацаанд нэр дэвшигчийн талаар мэдээлэл түгээхээс зайлсхийнэ” гэсэн зарчим юм. Ингэснээр Монголын сэтгүүлчдийн баримтлах Ёс зүйн зарчим 10 заалттай болж байгаа юм.

Улаанбаатар хот

2019 оны 5 дугаар сарын 03

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗӨВЛӨЛ

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс зөвлөж байна!**Онцгой байдалд редакцын баримтлах ёс зүйн зарчим**

COVID-19 онцгой нөхцөл байдлын үед иргэдэд худал мэдээлэл тарахаас сэргийлэх, сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагыг хэвлэлийн эрх чөлөөнд халгүйгээр үйл ажиллагаагаа саадгүй явуулахыг дэмжих зорилгоор Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс дараах зөвлөмжийг хүргэж байна.

Онцгой нөхцөлд хэвлэл мэдээллийн редакцууд мэргэжлийн түвшинд, ёс зүйн зарчмаа баримтлан ажиллаж, бодит мэдээлэл түгээснээр олон нийтийг зөв үйлдэлд чиглүүлнэ. “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ыг өдөр тутмын сэтгүүл зүйн үйл ажиллагаандаа чанд сахин мөрдөхөөс гадна дараах ёс зүйн зарчмуудад онцгойлон анхаарлаа хандуулахыг зөвлөж байна.

- Үнэн бодит байдлыг эрхэмлэх: Олон түмэнд үнэнд нийцсэн мэдээлэл хүргэх, хүнлэг ёс, хүн чанарыг эрхэмлэх нь сэтгүүл зүйн эрхэм дээд үнэт зүйл мөн. Мэдээллийн үнэн зөвийг таних эхний алхам нь мэдээллийг түгээгч нь найдвартай, баталгаатай эх сурвалж мөн эсэхийг нягтал. Мэдээллийг түгээхдээ хүнлэг байх, олон нийтийг айдас, хүүдэс, эрсдэлт таагүй нөхцөл байдал руу хөтлөхөөс болгоомжилж, зөвхөн үнэнд нийцсэн мэдээллийг түгээхэд анхаарна.
- Олон ургальч мэдээллээр хангах: Албан ёсны эх сурвалжийн мэдээллээс гадна эрүүл мэндийн чиглэлийн эрдэмтэн судлаачдын байр суурь, халдвар судлалын шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, эрдэм шинжилгээний өгүүлэл зэрэг баримт бичгүүд, халдварт өвчин нь нийгмийн бусад салбарт хэрхэн нөлөөлж буй талаарх судлаачдын ажиглалт, тандалтыг олон нийтэд түгээж, тэдний шийдвэр гаргалтад зөвөөр туслахыг хичээнэ.
- Мэдээллийг дахин дахин нягтлах: Мэдээллийг нягтлах нь сэтгүүл зүйн нягт, нямбай үйл ажиллагааны үндсэн зарчим мөн. Баталгаатай, найдвартай эх сурвалжаас мэдээлэл авч, уг мэдээллийг үнэн бодитой эсэхийг ердийн үеэс ч илүү давтан нягтал. Мэдээллийг нягталж шалгахдаа олон талын эх сурвалжаар харилцан баталгаажуулах, тохирох гол эх сурвалжийг сонгоход онцгой анхаар.
- Ялгаварлан гадуурхахгүй, доромжлохгүй байх: Хэнийг ч арьс өнгө, яс үндэс, гарал

угсаа, эрүүл мэнд, гэр бүлийн байдлаар нь ялгаварлан гадуурхалтын золиос болгож болохгүй. Ялангуяа коронавируст халдварыг хэн ч тусах эрсдэлтэй нөхцөл байдалд халдвар туссан, сэжигтэй, эмчлэгдсэн тохиолдлууд болон гадны иргэд, гадаадаас ирсэн Монгол иргэдийн талаар мэдээлэхдээ ялгаварлан гадуурхсан, гутаан доромжилсон, үзэн ядсан, буруутгасан өнгө аяс, үг хэллэгийг ашиглахгүй байхыг эрмэлзэнэ.

- Хувийн нууцад хүндэтгэлтэй хандах: Бие болон сэтгэл санааны эмгэг, эрүүл мэндийн тухай мэдээлэл нь хувийн нууцад хамаарах тул тухайн хүний болон асран хамгаалагчийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлж, нэвтрүүлэхийг цээрлэнэ. Ялангуяа коронавируст халдвараар өвчилсөн, сэжигтэй тохиолдлоор бүртгэгдсэн хүмүүсийн овог нэр, гэрийн хаяг, сургууль, ажлын газрын байршил, гэр бүл зэрэг тухайн хүнийг таниулах мэдээллийг олон нийтэд түгээхээс түдгэлзэнэ.
- Залруулга хийх, уучлал гуйх: Өдөр тутмын мэдээлэл тогтмол шинэчлэгдэж, олон нийтийн анхаарал нэг асуудалд чиглэсэн онцгой нөхцөлд сэтгүүлчид ажиллаж буй тул мэдээ, сурвалжилгадаа баримтын ямар нэг алдаа гарсан бол тэр даруйд нь шуурхай засч, залруулгыг нийтэлж нэвтрүүлэх, хэн нэгний нэр төрд санамсар болгоомжгүйн улмаас халдсан, буруу ташаа мэдээлэл түгээсэн бол уучлал гуйх нь урьд урьдынхаас ч илүү чухал болоод байна.

Ёс зүйн зарчмаа баримталцгаая!

Хэвлэл мэдээллийн зөвлөл

2020.04.22

Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим

Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн нэгдсэн хуралдааны нэгдүгээр тогтоолын хавсралт

Монгол улсын Үндсэн хуульд заасан үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийг хамгаалан бататгаж, Монголын сэтгүүл зүйн хэм хэмжээ нь хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний олон улсын хэм хэмжээг сахин мөрдөж буйг энэхүү ёс зүйн зарчмаар илэрхийлж байна.

Ёс зүйн зарчмууд	Удирдамж /тайлбар
<p>1. Олон түмэнд үнэнд нийцсэн мэдээлэл хүргэх, хүнлэг ёс, хүн чанарыг эрхэмлэх нь сэтгүүл зүйн эрхэм дээд үнэт зүйл мөн. Мэдээллийг нягтлах нь сэтгүүл зүйн нягт, нямбай үйл ажиллагааны үндсэн зарчим болно.</p>	<p>1.1 Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ.</p> <p>1.2 Эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягталж, тодорхой дурьдахыг эрмэлзэнэ.</p> <p>1.3 Бүтээлийн гарчиг, зураг, дүрс, дуу, график, ишлэл зэрэг нь агуулгыг буруугаар ойлгуулах, хэт хялбарчлах, мэдээллийг нөхцөл байдлаас салгаж мушгин гуйвуулах ёсгүйг үргэлж санаж, ийм зөрчил гаргахгүйн төлөө ажиллана.</p> <p>1.4 Фото, видео, аудио мэдээллийн агуулгыг техникийн арга хэрэгслээр гуйвуулахгүй.</p> <p>1.5 Нөлөөллийн болон мэдээллийн бүтээлийг ялгаж, мэдээнд үзэл бодол оруулахаас татгалзана.</p> <p>1.6 Баталгагүй мэдээлэл, таамаглал, ам дамжсан яриаг таамаг хэмээн тодорхой дурьдана.</p> <p>1.7 Хэвлэлийн мэдээг өөрчлөлтгүйгээр нийтэлж, нэвтрүүлбэл редакцын агуулгаас ялгаж тэмдэглэнэ.</p> <p>1.8 Буруутгагдсан, шүүмжлэгдсэн этгээдэд тайлбар өгөх боломж олгоно.</p> <p>1.9 Нийтэлж, нэвтрүүлсэн мэдээлэл нь ташаа болох нь тогтоогдсон мэдээллийг нэн даруй залруулна.</p>
<p>2. Мэдээллийг шударга бус аргаар олж авахгүй.</p>	<p>2.1 Сэтгүүлч өөрийгөө танилцуулж, ил тодоор ажиллах нь энэхүү мэргэжлийн үндсэн зарчим болно. Зөвхөн олон нийтийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий, өөр аргаар олж авах боломжгүй мэдээллийг бусад аргаар авч болно.</p> <p>2.2 Мэдээлэл олж авах бусад арга гэдэгт өөрийн болон байгууллагын нэрийг худал хэлэх буюу хэлэхгүй байх, дарамтлах, айлган сүрдүүлэх, сэтгэл санааны онцгой байдлыг ашиглах, нууцаар бичлэг хийх болон тагнаж чагнахыг хамаатуулна.</p> <p>2.3 Хувийн гэрэл зураг, дүрс бичлэгийг ашиглах тохиолдолд тухайн хүний болон насанд хүрээгүй хүмүүсийн асран хамгаалагчийн зөвшөөрлийг авна.</p>

	<p>2.4 Өөрийгөө хамгаалах чадваргүй буюу бусдаас хамаарал бүхий хүнээс мэдээлэл, гэрэл зураг авахдаа мэдрэмжтэй хандана. Энэ нь юун түрүүнд оюун санааны болон бие махбодийн хувьд өөрийгөө захирах чадваргүй, сэтгэл санааны хүнд байдалд орсон хүнд хамаарна.</p> <p>2.5 Насанд хүрээгүй хүнээс зөвхөн эцэг, эх асран хамгаалагчийнх нь зөвшөөрөлтэйгөөр мэдээлэл авч болно.</p>
<p>3. Хэнийг ч арьс өнгө, яс үндэс, гарал угсаа, хүйсийн байдал, нас, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, гэр бүлийн байдлаар нь ялгаварлан гадуурхалтын золиос болгохгүй.</p>	<p>3.1 Гэмт хэргийн талаар мэдээлэхдээ тухайн хүний харьяалал шашин, үндэс угсаа, бусад цөөнхийн төлөөлөл рүү зөвхөн тухайн хэргийг ойлгоход маш чухал тохиолдолд хэрэглэнэ.</p> <p>3.2 Хэвлэл мэдээллийнхэн нийгэмд оршиж байгаа хэвшмэл ойлголтуудыг улам дэвэргэхээс зайлсхийнэ.</p>
<p>4. Аливаа мэдээллийг зохисгүй хэлбэрээр дуулиантайгаар түгээхээс татгалзана.</p>	<p>4.1 Гэмт хэрэг үйлдэгдсэн аргыг нарийвчлан харуулсан нийтлэл, нэвтрүүлэг хийхээс зайлсхийнэ.</p> <p>4.2 Шүүх гэм буруутайг нь нотлоогүй бол хэнийг ч гэм буруутай гэж үзэхгүй.</p> <p>4.3 Гэмт этгээдийн талаар үлгэрлэн дууриах, шүтэх өнгө аясаар нийтэлж, нэвтрүүлэхгүй.</p> <p>4.4 Золгүй явдал, осол, хүчирхийллийн талаарх зураг, дүрсийг мэдээлэхдээ тухайн зураг, дүрс нь хүүхэд, өсвөр үеийнхэнд хэрхэн нөлөөлөх магадлалыг харгалзана.</p> <p>4.5 Гамшиг, осол, гэмт хэргийн улмаас хохирогсдын цогцсыг нарийвчлан харуулахгүй.</p> <p>4.6 Осол, гамшиг, гэмт хэргийн зураг, дүрсийг нийтэд хүргэхдээ тухайн хэргийн золиос, түүний ойр дотныхон болон хүүхэд, өсвөр үеийнхэнд уг дүрс хэрхэн нөлөөлж болохыг харгалзаж, онцгой няхуур бөгөөд мэдрэмжтэй хандана.</p>
<p>5. Мэдээллийг мушгин гуйвуулах, бусдыг гүтгэх, доромжлох, мэргэжлийн давуу байдлаар урвуулан мэдээллийг хувийн зорилгод ашиглахгүй. Мөн мэдээлэх, эс мэдээлэхийн тулд аливаа хэлбэрийн авлига авахаас татгалзана.¹</p>	<p>5.1 Гуравдагч талын санхүүжилтээр аялалд хамрагдсан бол аяллын тухай мэдээлэлд санхүүжилтийн талаар тодорхой дурьдана.</p>
<p>6. Хувийн нууцад хүндэтгэлтэй хандана.</p>	<p>6.1 Хэргийн сэжигтэн этгээдийн нэр, хувийн мэдээлэл болон зургийг бусдад танигдахуйц байдлаар нийтэлж, нэвтрүүлэхдээ хувь хүний эрхийг хамгаалах шаардлагыг харгалзана.</p>

	<p>6.2 Зөвхөн олон нийтийн тусын тулд хүний нэр, зураг болон бусад хувийн мэдээллийг нийтэд ил болгоно.</p> <p>6.3 Олон нийтийн тусын тулд гэдэг ойлголтыг “олон нийтэд сонирхолтой” мэдээлэлтэй эндүүрч болохгүй.</p> <p>6.4 Гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүний нэр, хувийн бусад мэдээллийг нийтэд дэлгэхгүй.</p> <p>6.5 Гэмт хэрэг, ослын хохирогчид нэр, нас, албан тушаал болон бусад хувийн мэдээллээ хамгаалуулах эрхтэй.</p> <p>6.6 Бие болон сэтгэл санааны эмгэг, эрүүл мэндийн тухай мэдээлэл нь хувийн нууцад хамаарах бөгөөд тухайн хүний болон асран хамгаалагчийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлж, нэвтрүүлэхийг цээрлэнэ.</p> <p>6.7 Амиа егүүтгэх тохиолдлыг харуулах, нэн ялангуяа нэрийг нь дурьдах, дүрс, нөхцөл байдлыг нь нарийвчлан харуулахаас зайлсхийнэ.</p> <p>6.8 Тухайн мэдээлэлтэй шууд холбоотой биш л бол гэмт хэргийн сэжигтэн, золиос, хүчирхийлэл, осол гамшигт өртөгсдийн гэр бүл, ойр дотны хүмүүсийн овог нэр, ажил, албан тушаал, гэрэл зураг, дүрсийг тэдний зөвшөөрөлгүйгээр нийтэлж, нэвтрүүлэхгүй.</p>
7. Бусдын уй гашуу, зовлон шаналалд хүндэтгэлтэй хандана.	
8. Мэдээллийн нууц эх сурвалжаа чандлан хамгаална.	
9. Төлбөрт нийтлэл, нэвтрүүлгийг тусгай тэмдэг, тэмдэглэгээгээр ялгана.	9.1 Далд зар сурталчилгааны аливаа хэлбэрээс татгалзана. ²
10. Сонгууль Хэвлэл мэдээлэл нь сонгуулийн санал хураалтаас өмнө буруутгагдсан этгээдийг тайлбар хийх боломжгүй хугацаанд нэр дэвшигчийн талаар мэдээлэл түгээхээс зайлсхийнэ. ³	

¹ ХМЗ-ийн Ёс зүйн хороодын 2015 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар өөрчлөлт оруулав.

² ХМЗ-ийн Ёс зүйн хороодын 2015 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар нэмэлт оруулав.

³ ХМЗ-ийн Ёс зүйн хороодын 2019 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар нэмэлт оруулав.

